

ШИНЭ МОНГОЛ ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ-Д 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 ШМТК-ийн оюутан элсүүлэхэд БСШУС-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам” болон энэхүү журмыг баримтална. Энэхүү журмыг баримтлахад БСШУС-ын 2016 оны 3-р сарын 16-ны А/87-р тушаалын 1.2.4 ба 2.2 нэмэлт өөрчлөлт үл хамаарна.
- 1.2 ШМТК-ийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.3 ШМТК-д элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “Бүртгүүлэгч”, зохих болзол хангаж, суралцах эрхийн бичиг гардан авсан бүртгүүлэгчийг “Элсэгч” гэнэ. Элсэлтийн ажлыг зохион байгуулахаар томилогдсон комиссыг “Элсэлтийн комисс”, элсэлтийн шалгалтыг зохион байгуулахаар томилогдсон комиссыг “Элсэлтийн шалгалтын комисс” гэнэ.
- 1.4 ШМТК-ийн Элсэлтийн комиссын дарга, түүний бүрэлдэхүүнийг гүйцэтгэх захирлын тушаалаар томилно.
- 1.5 Элсэлтийн шалгалтын комисс нь элсэлтийн үед баримтлах хэм хэмжээ, дэг журам тогтоох, элсэгчдийн материалыг хянах, өргөдөл гомдлыг барагдуулах, элсэлтийн явцад хяналт тавих, бичиг болон цахим бүртгэл хийх, үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.6 ШМТК-д нийслэл хот болон орон нутгаас элсүүлэх нийт оюутны хяналтын тоог ШМТК-ийн удирдах зөвлөл тогтооно.
- 1.7 Элсэлтийн шалгалтыг 6-р сард зохион байгуулах ба тухайн нөхцөл байдлаас хамаарч гүйцэтгэх захирлын тушаалаар 8-р сард “намрын элсэлт” авч болно.
- 1.8 Элсэлттэй холбоотой мэдээллийг ШМТК-ийн зарлалын самбар, цахим хуудас www.nmct.edu.mn болон <https://www.facebook.com/NMkosen> (New Mongol KOSEN “Шинэ Монгол Технологийн коллеж” нэртэй) өөрийн цахим хуудсанд байрлуулна.
- 1.9 Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал Элсэлтийн шалгалтын комисс шийдвэрлэнэ.

ХОЁР. ШМТК-ИЙН ЭЛСЭЛТ АВАХ ХӨТӨЛБӨРҮҮД

- 2.1 Дараах мэргэжлийн чиглэл, хөтөлбөрт оюутан элсүүлнэ. Үүнд:
 - 2.1.1 Цахилгааны инженер С071304 /Анги дүүргэлт 30 суралцагч/
 - 2.1.2 Механик инженер С071501 /Анги дүүргэлт 30 суралцагч/
 - 2.1.3 Барилгын инженер С073202 /Анги дүүргэлт 30 суралцагч/
 - 2.1.4 Химийн инженерчлэл С071101 /Анги дүүргэлт 30 суралцагч/
 - 2.1.5 Компьютерийн ухаан С061301 /Анги дүүргэлт 30 суралцагч/

ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ЭЛСЭЛТИЙН НӨХЦӨЛ

- 3.1 Бүртгүүлэгч нь бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
- 3.2 Бүртгүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 3.2.1 ШМТК-ийн 1-р курсэд Бүртгүүлэгч нь ЕБС-ийн 9-р ангийг төгссөн буюу суурь боловсрол эзэмшсэн сурагч байна.
 - 3.2.2 ШМТК-ийн 2-р курсэд Бүртгүүлэгч нь ЕБС-ийн 10-р ангийг төгсөгч байна.
 - 3.2.3 Бүртгүүлэгч нь ирээдүйд Монгол орныхоо бүтээн байгуулалтад гар бие оролцох хүсэл эрмэлзэлтэй байна.
 - 3.2.4 Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн суралцагч ШМТК-д элсэх хүсэлт гаргахдаа ЕБС-тай дүйцүүлж болох шалгалтыг гадаад оронд өгсөн болохыг гэрчилсэн баримтыг БШУЯ-наас баталгаажуулсан тодорхойлолтын хамт бүрдүүлж, Элсэлтийн комисст ирүүлнэ.
 - 3.2.5 Бүртгүүлэгч нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны дээд байгууллага суурь боловсролын хөтөлбөртэй дүйцэх хөтөлбөртэй гэж итгэмжилсэн Монгол улсад байрлах дотоодын болон гадаад улсын харьяа сургууль, институтийг төгссөн байж болно.
 - 3.2.6 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага суурь боловсролын хөтөлбөртэй дүйцэх болон илүү мэдлэг чадвартай гэж итгэмжилсэн сурагчийг мөн бүртгэн авна.

ДӨРӨВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

- 4.1 Элсэлтийн бүртгэл цахимаар явагдана.
- 4.2 Бүртгэлийн хугацаа 2022.05.10 - 2022.06.03-ны өдрийн 15:00 цаг хүртэл <http://202.21.114.244/kosen/> хаягаар орж бүртгүүлнэ.
- 4.3 Бүртгүүлэхэд анхаарах зүйлс:
 - 4.3.1 Бүртгүүлэгч нь ЕБС-ийн 9-р ангийг төгсөгч байх.
 - 4.3.2 Бүртгүүлэгчийн овог, нэрийг крилл үсгээр бичиж, регистрийн дугаарыг алдаагүй зөв оруулах.
 - 4.3.3 Бүртгүүлэгч цээж зургаа системд оруулахдаа сүүлийн 6 сарын дотор авахуулсан зургийг зөвхөн регистрийн дугаараар хадгалан, түүнийгээ оруулах /jpeg, png, jpg өргөтгөлтэй байх/.
 - 4.3.4 Бүртгүүлэгч өөрийн и-мэйл хаяг, холбоо барих утасны дугаарыг заавал бичих.
 - 4.3.5 Бүртгүүлэгч нь дараах 3 асуултад хариулж **word** эсвэл **pdf** файлаар хавсаргаж оруулна.
 - Танд байдаг хамгийн чухал 3 чадварын талаар тоочиж бичнэ үү?
 - Таны ирээдүйн зорилго, хүсэл мөрөөдөл юу вэ?
 - Яагаад Шинэ Монгол технологийн коллежийг сонгон суралцахаар шийдсэн бэ?

ШИНЭ МОНГОЛ ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ-Д 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

- 4.3.6 Бүртгэлийн явцад бүртгэлийн хураамж 15,000 /арван таван мянга/ төгрөгийг төлөхдөө дараах бэлтгэлийг хангаж бүртгэлийн системд хандана уу.
- Бүртгэлийн хураамж төлөх зааврыг бүртгэлийн нүүр хуудаснаас үзнэ.
 - Бүртгэлийн хураамжийг <http://202.21.114.244/kosen/> хаягаар нэвтрэн орж QPAY үйлчилгээг ашиглан QR код уншуулан Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Богд банк, Улаанбаатар хотын банкны аппликейшн ашиглан төлнө. /Голомт банкаар төлөх боломжгүй/
- 4.3.7 Бүртгүүлэгчтэй ярилцлагад хамт оролцох хүний талаар бүртгэлийн системд тохирох сонголтыг хийнэ.
- 4.3.8 Бүртгүүлэгч нь цахим бүртгэлд нэг л удаа бүртгүүлэх боломжтой.
- 4.3.9 Бүртгэл амжилттай болсноор бүртгүүлэгч цахим бүртгэлийн системд нэвтэрч шалгалттай холбоотой аливаа мэдээллийг шуурхай авах эрх үүснэ.
- 4.3.10 Бүртгүүлэгч нь цахим бүртгэл хаагдсаны дараа, дараах мэдээллийг бүртгэлийн хуудаснаас харах боломжтой болно.
- Бүртгэлийн дугаар
 - Шалгалтын хуваарь, бусад мэдээлэл

ТАВ. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ БА МЭДЭГДЭХ

- 5.1 Элсэгчийг шалгах үйл явцыг дараах 2 үе шаттайгаар зохион байгуулна.
- 5.1.1 **Бичгийн шалгалт.** Энэ шалгалтаар суурь боловсролын түвшний математик, физик, химийн хичээлийн ерөнхий мэдлэг болон техник сэтгэлгээний сорилоор шалгах ба нийт 110 оноогоор дүгнэнэ.
- 5.1.2 **Ярилцлагын шалгалт.** Энэ шалгалтаар бүртгүүлэгчийн инженер технологийн чиглэлээр сурах сонирхол болон хүсэл эрмэлзэл, өөрийгөө илэрхийлэх чадвар, эцэг эхийн хамтын ажиллагааг шалгах ба шалгагч багш нар бүртгүүлэгч тус бүртэй ганцаарчлан ярилцах хэлбэрээр уг шалгалтыг авна.
- 5.2 Бичгийн ба ярилцлагын шалгалтын оноонд үндэслэж, Элсэлтийн шалгалтын комиссын шийдвэрээр бүртгүүлэгчид элсэх эрх олгоно.
- 5.3 Элсэлтийн шалгалтын дүнг цахим хуудас болон сургуулийн мэдээллийн самбарт байршуулна.
- 5.4 ШМТК-ийн багш, ажилтнуудын хүүхэд элсэх хүсэлт гаргасан тохиолдолд энэ журмын 3.2 дахь заалтыг хангаж байвал багш, ажилтны хүсэлтийг үндэслэн онооны дараалал харгалзахгүйгээр гүйцэтгэх захирлын тушаалаар элсүүлж болно.

ЗУРГАА. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

- 6.1 Элсэлтийн батламж олгох өдрийг бүртгэлийн хугацаа тодорхой болмогц зарлана.
- 6.2 Элсэлтийн шалгалтын комиссын шийдвэрээр элсэх эрх авсан элсэгчдэд ШМТК-д суралцах эрхийн бичиг (батламж) – ийг зарласан хугацаанд гардуулна.
- 6.3 Элсэгч ШМТК-оос товлосон хугацаанд суралцах гэрээг байгуулан, сургалтын төлбөрийг төлсний дараа элсэн суралцах эрх баталгаажиж гүйцэтгэх эрх баталгааж гаргана. Суралцах гэрээ байгуулах хугацаа болон бусад мэдээллийг элсэх батламж гардуулах үед мэдээллэнэ.
- 6.4 Элсэх эрх олгох үед бүртгэлийн мэдээллийг эх бичиг баримтуудтай нь тулгаж баталгаажуулна.
- 6.5 Тус сургуульд элсэгч нь Улсын аварга шалгаруулах математик, физик, химийн олимпиадад амжилттай оролцож “1-10”-р байрт шалгарсан тохиолдолд ШМТК-д элсэн суралцах эрхийн бичиг гардан авсан бол тус сургуульд элсэн суралцах хүсэлт ирүүлснээр зөвхөн ярилцлагын шалгалт авч түүний дүнд үндэслэн элсүүлж болно.
- 6.6 Тухайн элсэгч нь сурлага, спорт, техник технологийн төрлөөр аймаг болон дүүрэг, улсын уралдаан тэмцээн, олимпиадад тасралтгүй амжилт үзүүлж, өөрийн хүсэлтээр тус сургуульд суралцах чин хүсэл эрмэлзэлтэй байвал зөвхөн ярилцлагын шалгалт авч түүний үр дүнд үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалаар элсүүлж болно.

ДОЛОО. БУСАД

- 7.1 Элсэх эрхийг бусад шилжүүлэхийг хориглоно.
- 7.2 Элсэх эрх авсан боловч хүндэтгэх шалтгаангүйгээр заасан хугацаанд ирж суралцах гэрээ байгуулаагүй элсэгчийг суралцахаас татгалзсан хэмээн үзэж элсэх эрхийн бичгийг хүчингүйд тооцно. Энэ тохиолдолд элсэлтийн шалгалтын оноогоор дараагийн шалгуулагчид мэдээлэн, түүний хүсэлтийг үндэслэн элсүүлж болно.
- 7.3 ШМТК-ийн элсэлт, цахим бүртгэл болон бусад мэдээллийг сургуулийн фэйсбүүк пэйж хуудас болон холбогдох утасны дугаараас авч болно.
- Холбогдох утасны дугаар: 99510543, 95020001

ШИНЭ МОНГОЛ ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРМЫН ХАВСРАЛТ /2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ/

1. ЭЛСЭЛТ АВАХ АНГИ, ОЮУТНЫ ТОО, БҮРТГЭЛ:

Элсэлт авах анги	Элсүүлэх оюутаны тоо	Бүртгэх хугацаа
1-р курс	26-30 (5 бүлэг)	Хавар V/ 10-VI/03-ны 15:00 цаг хүртэл цахимаар
2-р курс	Цөөн тоогоор: Химийн инженер Механикийн инженер Компьютерийн ухаан	Хавар V/ 10-VI/03-ны 15:00 цаг хүртэл цахимаар

2. ШАЛГАЛТ АВАХ ХУГАЦАА, ХИЧЭЭЛ:

Анги	Шалгалт авах хугацаа	Шалгалт авах хичээл
1-р курс	Бичгийн шалгалт 120 минут Ярилцлага 15-20 минут	Математик -60 оноо Физик-20 оноо Хими-20 оноо Бүтээлч сэтгэлгээ – 10 оноо Ярилцлага-40 оноо
2-р курс	Бичгийн шалгалт 120 минут Ярилцлага 15-20 минут	Математик-40 оноо Физик-30 оноо Хими-30 оноо Ярилцлага-40 оноо

3. ЭЛСЭЛТИЙН ДҮН МЭДЭЭ:

Шалгалтын дүн мэдээг 6-р сарын 05-ны өдөр сургуулийн мэдээллийн самбар, вэб сайт, фэйсбүүкт байршуулна. Тэнцсэн оюутан 6-р сарын 06-ны өдрийн 12:00 цагт батламжаа гардаж авна.

4. ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЭЛСЭЛТ: / зөвхөн 10-р анги буюу 1-р курсэд хамаарна./

Математик, байгалийн ухааны, аймаг, хотын медальт сурагчдыг (50%), Улсын болон ОУ-ын олимпиадын медальт сурагчдыг (100%) тэтгэлгээр суралцуулна.

5. **ХАРИЛЦАХ УТАС:** 9502001, 99510543

6. **НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ:** Шалгалтанд зориулсан сургалт, бэлтгэл хичээллэхгүй.

7. **СУРГАЛТЫН ТӨЛБӨР:** 4'900'000 /Дөрвөн сая есөн зуун мянга/ төгрөг

8. **СУРГУУЛЬ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ.** 5-р сарын 7, 21